

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуульд доор дурдсан агуулгатай 6.10, 7.5 дахь хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 10 дахь хэсэг:

“6.10.Импортлох тамхины нэр төрөл, тоо хэмжээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хоёр жил тутамд тогтооно. Нэр төрөл, тоо хэмжээ тогтоохтой холбогдсон журмыг Засгийн газар батална.”;

2/7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“7.5.Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч сунгуулах хүсэлт гаргаагүй бол тамхи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болсонд тооцно.”

2 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 7.1 дэх хэсгийн “... тамхины ургамал тарих тусгай зөвшөөрлийг” гэсний өмнө “тамхи импортлох,” гэж, 7.2 дахь хэсгийн “тамхи үйлдвэрлэх...” гэсний дараа “тамхи импортлох” гэж тус тус нэмсүгэй.

ГАРЫН ҮСЭГ